

**ЖЕНЕВ ХОТНОО 1958 ОНД БАТЛАГДСАН “ДУГУЙТ ТЭЭВРИЙН ХЭРЭГСЛҮҮД,  
ТЭДГЭЭРТ СУУРИЛУУЛАН АШИГЛАЖ БОЛОХ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ, ЭД АНГИД  
ЗОРИУЛСАН НЭГДСЭН ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН УЯЛДУУЛАН  
ТОХИРУУЛСАН ТЕХНИКИЙН ДҮРМИЙГ ХЭРЭГЛЭХ БОЛОН НЭГДСЭН  
ҮНДЭСТНИЙ БАЙГУУЛЛАГЫН ЭДГЭЭР ДҮРЭМД ҮНДЭСЛЭН ОЛГОСОН  
БАТАЛГААГ ХАРИЛЦАН ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ НӨХЦӨЛИЙН ТУХАЙ  
ХЭЛЭЛЦЭЭР”-ИЙГ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ  
ХЭЛЭЛЦСЭН ТАЛААРХ АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД БОДЛОГЫН  
БАЙНГЫН ХОРООНЫ САНАЛ, ДҮГНЭЛТ**

2023 оны 03 дугаар  
сарын 23-ны өдөр

Улаанбаатар  
 хот

**Илтгэгч: Улсын Их Хурлын гишүүн Г.Амартувшин**

Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хуралд Монгол Улсын Засгийн газраас 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр өргөн мэдүүлсэн Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 78 дугаар зүйлд заасны дагуу Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 2023 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хуулийн төслийг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Амартувшин гадаадаас импортлож байгаа тээврийн хэрэгсэл, хуурамч, дуураймал тоног төхөөрөмж, сэлбэг, стандарт бус тоноглол суурилуулах зэрэг асуудлууд уг хэлэлцээрийг соёрхон баталснаар цэгцэрэх, импортоор оруулж ирдэг машины түүх, арлын дугаар нь дэлхийн бусад улс орнуудын нэгэн адил нэгдсэн системд бүртгэгдэх эсэх тухай болон буруу талдаа жолооны хүрдтэй тээврийн хэрэгслийг цаашид хэрхэн шийдвэрлэх талаар, Улсын Их Хурлын гишүүн Н.Энхболд уг хэлэлцээрийг соёрхон баталснаар Бүгд Найрамдах Солонгос Улсаас манай улс руу тээврийн хэрэгслийг импортлохоос өмнө Нэгдсэн Үндэстний Байгууллагаас тавьдаг шаардлагад нийцсэн эсэхэд хяналт хийж, оруулж ирэхгүй байх нөхцөл бүрдэх эсэх талаар ажлын хэсгийн гишүүдээс асуулт асууж, хариулт авсан.

Хуулийн төслийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжиж, 70 хувийн саналаар соёрхон батлах нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Женев хотноо 1958 онд батлагдсан “Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр”-ийг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцсэн талаарх Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын

хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж, хуулийн төслийг баталж өгөхийг  
Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ГАДААД  
БОДЛОГЫН БАЙНГЫН  
ХОРООНЫ ДАРГА



Б.ЭНХ-АМГАЛАН

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2023 оны ... дугаар  
сарын ...-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Швейцарь Улсын Женев хотноо 1958 онд батлагдсан "Дугуйт тээврийн хэрэгслүүд, тэдгээрт суурилуулан ашиглаж болох тоног төхөөрөмж, эд ангид зориулсан НҮБ-ын Нэгдсэн Үндэстний Байгууллагын уялдуулан тохируулсан техникийн дүрмийг хэрэглэх болон НҮБ-ын Нэгдсэн Үндэстний Байгууллагын эдгээр дүрэмд үндэслэн олгосон баталгааг харилцан хүлээн зөвшөөрөх нөхцөлийн тухай хэлэлцээр"-ийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

Гарын үсэг